



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/188

Булган сум

Оросын Холбооны Улсын Буриад Улсад
айлчлал хийх зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын орлогч Д.Жаргалсайхан тэргүүтэй ажлын хэсэг Оросын Холбооны Улсын Буриад улсад айлчлал хийх зардалд 4,006,000 (дөрвөн сая зургаан мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн Дэлхийн Алтаргана-2024 төлөвлөгдсөн хөрөнгөнөөс 1,170,000 (нэг сая нэг зуун далан мянга) төгрөгийг санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д, Тамгын газрын төсвөөс 2,836,000 (хоёр сая найман зуун гучин зургаа мянга) санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай) -д тус тус санхүүжүүлэхийг зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ӨРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 28-ны өдрийн А.А.88 дугаар
захирамжийн хавсралт



Оросын Холбооны Улсын Буриад Улсад
айлчлал хийх зардалын төсөв

Д/д	Шаардагдах зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	2	3	4	5
1	Шатахуун	464 литр	2520	1,17000
2	Томилолт	2 хүний 2 өдөр	70900	2,836,000
3		Нийт		4,006,000